



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/201

Бат-Өлзий сум

Газрын дуудлага худалдаа зохион  
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 9.1, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөө батлах тухай" 2022 оны 11 дүгээр сарын 23-ний өдрийн 10/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэр ХААН банкны урд байрлах худалдаа, үйлчилгээний зориулалттай 500 м<sup>2</sup> газар эзэмшүүлэх газрын дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Дуудлага худалдаа хөтлөгч: Э.Хорлоо (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газрын төлбөр, татвар үнэлгээний хариуцсан мэргэжилтэн)

Тэмдэглэл хөтлөгч: Н.Түвшин (Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

2. Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг хууль тогтоомж, дүрэм журмыг баримтлан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, шударга, ил тод, нээлттэй зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН